# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр  Дугаар 649  Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гадаадын иргэн, харьяатын газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан автомашины (3 дахь) нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2.Автомашины худалдах доод үнийг 30 хувиар бууруулан, хавсралтаар тогтоосугай.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

0002733

D:\Huraldaanii material\2018 on\2018.12.25\Togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
649 дугаар тогтоолын хавсралт

## ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ГАДААДЫН ИРГЭН ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИН

| Д/д | Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар | Ашиглалтад орсон он | Нийт гүйлт (км) | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | ТӨБЗГ-ын 2016 оны 158 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг ) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёота ландкруйзер-100, 70-40 СЭҮ (арал-uzj1000021986) | 2007 | 385700 | 30,000,000.00 | 29,663,880.91 | 336,119.09 | 13,000,000.00 | 9,100,000.00 |
| | Нийт дүн | | | 30,000,000.00 | 29,663,880.91 | 336,119.09 | 13,000,000.00 | 9,100,000.00 (есөн сая нэг зуун мянган) |